



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын компаниудын хувьцааны ханш энэ долоо хоногт тогтвортой байлаа.

Мягмар гаригт тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Caterpillar компанийн эрх бүхий албан тушаалтнууд компанийн ашгийн хэмжээ буурах магадлалтай талаар мэдээлсэн нь тус компанийн хувьцааны ханш унахад нөлөөлжээ. 3М компанийн ашгийн хэмжээ буурсан явдал тус компанийн зах зээлийн үнэлгээг багасгасан байна. Facebook болон Amazon.com компаниудын орлогын тайлангийн эерэг үзүүлэлтүүд тус компаниудын хувьцааны ханшийг 9% болон 4%-аар өсөхөд нөлөөлсөн байна.

**Европ:** Европын компаниудын 1-р улирлын тайлан гарч Европын индексүүд өсөлттэй байлаа.

Франц улсын Ерөнхийлөгч Ноён Эммануэл Макрон АНУ-ын Вашингтон хотноо айлчилж, АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамптай уулзан тус улсын баримталж буй худалдааны бодлогод шүүмжлэлтэй хандаж байгаагаа илэрхийлсэн байна. Германы канцлер Ангела Меркел АНУ-д айлчлал хийн, хоёр улсын хэрэгжүүлж буй худалдааны бодлогын талаар хэлэлцээр хийжээ.

Европын компаниудын 1-р улирлын тайлангийн үзүүлэлт салбар салбараараа ялгаатай байсан хэдий ч зах зээлийн индексийг өсгөсөн байна.

Европын Төв Банк мөнгөний бодлогондоо өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэв. Тус байгууллагын Ерөнхийлөгч Ноён Марио Драги Европын бүсийн эдийн засаг хэт хурдан удааширч байгааг онцолжээ.

Их Британийн Статистикийн Хороо энэ оны 1-р улиралд тус улсын эдийн засаг 0.1%-аар өссөн тухай мэдээлсэн ба тус үзүүлэлт нь сүүлийн таван жил тохиогоогүй хамгийн бага үзүүлэлт аж.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш 5 долоо хоног дараалан өсжээ. Иений ханш ам. долларын эсрэг 109.2 нэгж болсон байна.

Японы Төв Банк богино хугацааны бодлогын хүүг -0.1%, урт хугацааны бодлогын хүүг 0% дээр барихаар шийдвэрлэлээ. Японы Төв Банкны бодлого зохицуулалтын хороо инфляцийн зорилтот 2% түвшинд хүрэх хугацааг хязгааргүй болгосон байна.

**БНХАУ:** АНУ, БНХАУ-ын төрийн тэргүүнүүд хоорондын худалдааны асуудлыг шийдвэрлэхийг оролдсоор байна.

Олон Улсын Валютын Сангийн урьдчилсан тооцоогоор энэ онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3.9%-тай тэнцэх аж. Тус үзүүлэлт нь сүүлийн зургаан жилд тохиогоогүй өндөр үзүүлэлт юм. Харин тус өсөлтөнд АНУ, БНХАУ хоорондын худалдааны асуудал сөргөөр нөлөөлөх боломжтой ажээ.

**Өмнөд Солонгос:** Өмнөд Солонгос, Хойд Солонгосын төрийн тэргүүнүүд 70 орчим жил үргэлжилсэн дайсангаас харилцаандаа цэг тавьж, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгохоор санал нэгдсэн байна. Тус үйл явдлын дараа Өмнөд Солонгосын компаниудын хувьцааны ханш өсөн, воны ханш чангарчээ.

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,148.26	-0.65% ▼
Dow Jones	АНУ	24,311.19	-0.62% ▼
S&P 500	АНУ	2,669.91	-0.01% ▼
Nasdaq	АНУ	7,119.80	-0.37% ▼
S&P/TSX	Канад	15,668.93	1.18% ▲
FTSE 100	Их Британи	7,502.21	1.82% ▲
S&P/ASX 200	Австрали	5,953.60	1.44% ▲
Nikkei 225	Япон	22,467.87	1.38% ▲
Hang Seng	Хонг Конг	30,280.67	-0.45% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	111.02
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.24
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.34
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	114.50
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.35
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.62
TDBM' 2020	USD	9.3%	106.73

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үө
Libor 1M	1.907	0.01 ▲
Libor 3M	2.358	-0.00 ▼
Libor 6M	2.520	0.01 ▲
Libor 1YR	2.780	0.02 ▲
US 6M Bond	2.004	0.01 ▲
US 2YR Bond	2.484	0.02 ▲
US 3YR Bond	2.618	-0.00 ▼
US 5YR Bond	2.801	-0.00 ▼
US 10YR Bond	2.957	-0.00 ▼

### Валютын ханш /төг/

Валют	2018.04.27	Өөрчлөлт
USD	2,401.65	0.28% ▲
CNY	378.73	-0.57% ▼
EUR	2,900.23	-1.76% ▼
RUB	38.22	-1.97% ▼
KRW	2.23	-0.45% ▼
JPY	21.95	-1.44% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,324.00	-0.77% ▼
Мөнгө /spot/	16.51	-3.22% ▼
Зэс	306.95	-3.23% ▼
Нүүрс	94.57	1.20% ▲
WTI газрын тос	68.1	-0.22% ▼
Brent газрын тос	74.64	0.89% ▲
Байгалийн хий	2.77	1.09% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.III	6.60%
Бодлогын хүү	2018.III	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.III	10.07%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.III	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.III	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.III	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.III	11.30%

**Эх сурвалж:** Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 56 компанийн 710.0 сая төгрөгийн 3,905,417 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хүннү менежмент” /NBZ/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсч 107.88 төгрөгт хүрч хаагдсан бол “Их Барилга” /IBA/ компанийн хувьцаа 19.51%-аар буурч 3,300 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр 1 удаагийн хэлцлээр нийт 365 ширхэг үнэт цаас 36.4 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр мөн л арилжаа явагдаагүй байна.


4-р сарын 20-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,521.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,279.62 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 4.37%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	782.8
Зах зээлийн үнэлгээ	2,483,912.2

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,148.26	-0.65% ▼
MSE I индекс	9,773.16	-1.68% ▼
MSE II индекс	9,892.13	0.14% ▲

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Жинст-Увс	161,842	247,380,222.0
ЛендМН ББСБ	3,094,467	142,874,667.2
АПУ	218,649	137,969,131.8
Таван Толгой	6,380	64,590,875.0
Говь	2,090	46,319,740.0

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хүннү менежмент	107.88	15.00% ▲
Улаанбаатар хивс	16,490.00	13.72% ▲
Баян-Алдар	650.00	12.07% ▲
Дөрвөн-Уул	2,150.00	10.26% ▲
Бөөний худалдаа	419.00	9.05% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Их Барилга	3,300.00	-19.51% ▼
Мон-Ит Булигаар	9,550.00	-14.96% ▼
Э-Транс Ложистикс	100.00	-13.04% ▼
Сор	1,100.00	-10.93% ▼
Бөхөг	3,800.00	-7.32% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард секьюритиз	301,334,666.89
БиДиСек	176,837,091.36
Мирэ Эссет Секьюритис Монгол	135,374,125.33
Ти Ди Би Капитал	134,264,877.97
Бумбат-Алтай	118,285,219.78

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	645.44	686,865
Таван толгой	10,070.00	530,339
МИК	11,250.00	232,980
Говь	22,120.00	172,561
Сүү	218.00	74,992

## ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-08/05/18-A0241-0	730.00	72,810,200.00	99,740.00	99,740.00	52	14.670%

## КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Компанийн бондын хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Нийт цэвэр ашиг /сая төгрөг/	Цэвэр ашигт эзлэх хувь /%/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой ХК	2140.00	126,923.13	141,054.64	90.0%	2018.03.16	2018.04.03	N/A
2	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	587.80	2,329.13	25.2%	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
3	AND	Анд-Энерги ХК	1.27	13.27	121,400.00	0.0%	2018.02.24	2018.03.16	N/A
4	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	1,070.68	61.0%	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
5	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2,430.13	42.5%	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
6	GTL	Гутал ХК	1,270.0	2,055.73	2,492.84	82.5%	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
7	BNG	Баянгол Зочид буудал ХК	355.0	150.19	2,481.23	6.1%	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
8	APU	АПУ ХК	10.0 0	10,641.82	24,871.94	42.8%	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
9	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	1,131.61	2.2%	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
10	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	492.98	2.8%	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
11	HRD	Хүрд ХК	497.00	67.23	694.41	9.7%	2018.02.15	2018.02.23	2018 оны II улиралд
12	MNP	Монгол шуудан ХК	3.68	367.25	911.83	40.3%	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
13	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	354.75	107.1%	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
14	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	1,128.02	15.4%	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
15	GHC	Ган Хийц ХК	100.00	24.20	(158.94)	N/A	2018.02.09	N/A	N/A
16	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	435.50	94.1%	2018.01.24	2018.03.01	N/A
17	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	247.12	16.4%	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
18	ТАН	Тахь-ко ХК	108.00	128.52	790.06	16.3%	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
19	GOV	Говь ХК	220.00	1,716.25	17,474.71	9.8%	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
20	HRM	Гермес Центр ХК	5.00	392.72	715.41	54.9%	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Хүрд” ХК ногдол ашиг тараахаар боллоо

МХБ-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй “Хүрд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нийт 67.2 сая төгрөг буюу нэгж хувьцаанд 497 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоосон ба ногдол ашгийг 2018 оны 2-р улиралд багтаан олгохоор болсон байна.

**Эх сурвалж:** MSE.mn

### “Атар Өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилжээ

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 4-р сарын 23-ны өдрийн 183/ШЗ2018/05104 тоот захирамжийн дагуу “Таван богд трейд” ХХК, “Улаанбаатар гурил” ХХК нарын нэхэмжлэхтэй, “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох иргэний хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 14 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэхээр болсон тул тус компанийн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр зарлагдсан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшуулахаар болсон байна.

**Эх сурвалж:** MSE.mn

### Анд Энерги: Ногдол ашгаа нэмж олгохоор боллоо

Анд Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 сарын 21-ний өдрийн 12:00-15:00 цагийн хооронд Орхон аймагт зохион байгуулагдлаа.

2018 оны 3-р сарын 16-ны өдөр буюу хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн байдлаар Компанийн эргэлтэд гаргасан 78,070,758 ширхэг энгийн хувьцааг нийт 432 хувьцаа эзэмшигч эзэмшиж байсан.

Дээрх хувьцаа эзэмшигчдээс Хуралд нийт 52,907,300 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 67,72% болох 64 иргэн, хуулийн этгээд оролцжээ.

Компанийн ТУЗ-ийн 2018 оны 2 сарын 24-ний өдрийн шийдвэрээр нэгж хувьцаанд 50 мөнгөний ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлээд байсан.

Хурлын үеэр Компанийн дөрвөн үүсгэн байгуулагчийн зүгээс өөрт хуваарилагдах ногдол ашгийн 80 хувийг зарлагдсан ногдол ашиг дээр нэмж бусад хувьцаа эзэмшигчдэд олгох болсон талаар мэдээлсэн юм. Ингэснээр Компанийн хувьцаа эзэмшигч нар нэгж хувьцаанд нийт 1,27 төгрөгийн ашгийг хүртэх эрхтэй болж байна.

**Эх сурвалж:** Erdenetled.mn



### “Тавантолгой” ХК 2017 оны цэвэр ашгийн 90 хувийг ногдол ашигт хуваарилна

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Тавантолгой” ХК 2017 оны цэвэр ашгийн 90 хувийг буюу нийт 127 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэлээ. Ингэснээр нэгж хувьцаанд 2410 төгрөг ногдож байна. Нүүрсний ханш өсөлттэй байсан 2017 онд тус компани дөрвөн сая тонн нүүрс олборлосон нь төлөвлөгөөнөөс хоёр дахин өндөр үзүүлэлт болжээ. Ингэснээр борлуулалтын орлого нь жилийн дүнгээр 2.4 дахин өсөж, 428 тэрбум төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК өнгөрсөн онд 184.3 тэрбум төгрөгийн татвар төлсөн талаар мэдээллээ. “Тавантолгой”-ийн хувьцааны ханш энэ онд сүүлийн долоон жилийн дээд цэг буюу 13 мянган төгрөгт хүрсэн юм. Ингэснээр зах зээлийн үнэлгээгээр Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудыг тэргүүлж байв. Харин сүүлийн байдлаар 10,070 төгрөг болсон байна. Энэ нь нэг жилийн хугацаанд хоёр дахин өссөн үзүүлэлт боллоо. Ингэснээр зах зээлийн үнэлгээ нь 530 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Б.Ганхуяг: Иргэд 1072 хувьцааны ногдол ашгаа 2019 оноос хүртэх боломж бүрдэнэ

“Эрдэнэс-Таван толгой” компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганхуяг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газар дэд дарга У.Бямбасүрэн нар мэдээлэл хийлээ.

Байгуулагдсан цагаасаа тогтмол алдагдалтай ажиллаж ирсэн “Эрдэнэс-Таван толгой” компани 2017 онд 1.1 их наяд төгрөгийн борлуулалт хийж 461.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Тус компани өнгөрсөн онд 1072 хувьцааг амилуулах хүрээнд 2.5 сая иргэнийг хувьцаа эзэмшигчээр, 11.2 их наяд төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгэж авсан. Ингэснээр компанийн үнэ 5 тэрбум ам.долларт хүрчээ. Түүнчлэн 8.5 сая тонн нүүрс экспортод гаргасан байна.

Компанийн зүгээс энэ оны 9 дүгээр сард Монголын Хөрөнгийн биржид хувьцаагаа гаргахаар төлөвлөсөн. Одоогоор Монголын хөрөнгийн биржид хувьцаа гаргахад тавих шаардлагыг 85 хувьтай хангасан бөгөөд цаашдаа олон улсын хөрөнгийн биржид гаргах чиглэлд ажиллахаар төлөвлөж байгаа аж. Ингэснээр 2019 онд иргэдэд ногдол ашиг олгох боломж бүрдэнэ гэдгийг мэдээллийнхээ төгсгөлд дурьдлаа.

**Эх сурвалж:** Montsame.mn

### “Жинст-Увс” ХК, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-тай нэгдлээ

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 4-р сарын 28-ны өдөр болж өнгөрлөө. Ард санхүүгийн нэгдлийн хувьцааг 3000 гаруй хүн эзэмшиж буй аж. Ард санхүүгийн нэгдэлд Ард даатгал, Ард кредит ББСБ, Ард секьюритиз Үнэт цаасны компани зэрэг 12 охин компани үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн онд Ард санхүүгийн нэгдлийн нийт хөрөнгө 39,4 тэрбум төгрөгөөс 49,7 тэрбум төгрөгт хүрч, 64 хувийн өсөлт үзүүлжээ. Нэгж хувьцааных нь ханш 20 хувиар өсч, 2955 төгрөгөөр үнэлэгдэж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан гол шийдвэр нь Монголын Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжиж буй “Жинст Увс” компаниаар нэгдэх асуудлыг хэлэлцэн 100 хувийн саналаар дэмжигдлээ. Ингэснээр Ард Санхүүгийн Нэгдэл нь 1000 төгрөгийн үнэтэй 28 614 263 ширхэг хувьцаатай болж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Жоншны экспорт | улиралд өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин нэмэгджээ

2018 оны I улиралд Монгол Улсын жоншны экспорт өнгөрсөн оны мөн үеэс хоёр дахин өсөж, 25 сая ам.долларт хүрсэн байна. Үүнээс тал хувийг нь БНХАУ, үлдсэнийг нь ОХУ-д экспортолсон байна. Биет хэмжээгээр тооцвол нийт 78.3 мянган тонн жоншны хүдэр болон баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 47.3 хувиар өссөн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Жоншны гол экспортлогчдын нэг болох "Баялаг жонш" ХХК I улиралд 5000 орчим тонныг экспортолжээ. Жилд дунджаар 20 мянга орчим тонн жонш экспортолдог "Баялаг жонш" ХХК энэ онд борлуулалтаа бага зэрэг нэмэгдүүлэхээр зорьж байгаа гэдгээ тус компанийн Гүйцэтгэх захирал П.Хурцбилэгт мэдээллээ.

Үнийн хувьд боловсруулагүй жонш нэг тонн тутамдаа 75-92 ам.доллар, баяжмал нь 92-97 ам.долларт хүрч байна. БНХАУ-ын зах зээлд ханш нь ойролцоогоор 30 ам.доллараар илүү байгаа ч хүндрэл бэрхшээл их гардаг гэдгийг "Баялаг жонш" ХХК мэдээллээ.

Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар хайлууур жоншны олборлолт, үйлдвэрлэл, экспортын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, санал боловсруулах үүрэгтэй ажлын хэсгийг байгуулаад байна. Ажлын хэсгийнхэн өнгөрсөн долоо хоногт салбарын 40 гаруй компанийн төлөөлөлтэй уулзжээ. "Жоншны салбарын бодлогыг эмх цэгцтэй болговол эрдэс бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж чадна" гэж талууд дүгнэсэн талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээлж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



### Aspire Mining: "Нүүрстэй" коксжих нүүрсний төслийн ТЭЗҮ-ийг 2018 онд боловсруулж дуусна

"Aspire Mining" компанийн хувьцааны ханш Австралийн Хөрөнгийн биржийн даваа гарагийн арилжаагаар 20 хувиар өсөж, 0.012 австрали доллар болсон байна. Тус компанийн Гүйцэтгэх захирал Дэвид Поулл "Pro-Active-Investors"-т өгсөн ярилцлагынхаа үеэр "Нүүрстэй" коксжих нүүрсний төслийн ТЭЗҮ-ийг энэ оны дундуур дуусгаж, улмаар ирэх онд олборлолт хийж эхлэхээр төлөвлөж байгаа талаар дурджээ. "Aspire Mining" компанийн хувьд эрдэс бүтээгдэхүүнээ ОХУ болон БНХАУ-ын зах зээлд гаргахад дэмжлэг болох дэд бүтцийн нөхцөл бүрдэхэд ойрхон байгаа аж. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-д айлчлах үеэр төмөр зам, дэд бүтэц болон хоёр орны хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн хэд хэдэн баримт бичиг, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан юм.

Мөн Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг тавдугаар сард багтаан боловсруулж дуусах зэргээр хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны талд БНХАУ-ын "China Gezhouba Group"-тэй харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

Эх сурвалж: BloombergTv.mn

### Өргөн хэрэглээний барилгын материалын 70 хувийг дотоодод үйлдвэрлэж байна

2017 онд барилгын материалын 20 орчим үйлдвэр шинээр ашиглалтад оржээ. Энэ нь өмнөх жилүүдийн дунджаас бараг хоёр дахин буурсан үзүүлэлт болж байна. Барилгын салбар дахь хөрөнгө оруулалт буурсан, ипотекийн зээл зогсонги байдалд орсон зэргээс шалтгаалан барилга угсралтын компаниуд болон материал үйлдвэрлэгчид хүнд байдалд орсон гэж Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны Гүйцэтгэх захирал О.Лхагвадорж мэдээллээ. Сүүлийн дөрвөн жилд ашиглалтад орсон компаниудаас цементийн томоохон үйлдвэрүүдийг эс тооцвол бүгд жижиг, дунд үйлдвэрүүд байгаа аж. Үйлдвэрүүдийн 75 хувь нь Улаанбаатар хотод төвлөрчээ. Таван жилийн өмнө хэрэглээнийхээ 88 хувийг импортоор хангадаг байсан бол одоо барилгад өргөнөөр хэрэглэгддэг 40 гаруй нэр төрлийн материалын 70 хувийг дотооддоо үйлдвэрлэх боломжтой болсон байна. Тухайлбал, бэлэн бетон зуурмаг, инженерийн болон иргэний барилгын бетон төмөр хийц эдлэлүүд, керамик тоосго зэргийг дотоодоосоо бүрэн хангах боломжтой болжээ. Мөн хуванцар хаалга цонх, сантехникийн хуванцар хоолой, дулаалгын хөөсөнцөр хавтан зэргийг нэрлэж болохоор байна. Түүнчлэн сүүлийн долоон жилд шинээр байгуулагдсан цементийн үйлдвэрүүдийн тоо зургаа дахин нэмэгджээ. Өөрөөр хэлбэл дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахаас гадна экспортод гаргах боломж бүрдсэн байна. Одоогоор ОХУ-д экспортлох боломжийг судалж байгаа талаар Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо мэдээллээ.

2016 онд цементийн томоохон төслүүд хэрэгжиж, жилд нэг сая тонн цементийг хуурай аргаар үйлдвэрлэх дөрвөн том үйлдвэр шинээр ашиглалтад орж байжээ. Энэ оны эхний улиралд 70.4 мянган тонн цемент үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гурав дахин өссөн үзүүлэлт болж байна.

Харин шохой үйлдвэрлэл жилийн дүнгээр гурав дахин, төмөр бетон үйлдвэрлэл 50 хувиар буурсан талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн юм. Үүнээс гадна вакуум цонх, хаалга үйлдвэрлэл дөрвөн хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

### ХААБ: Боловсруулагүй цайвар ноолуурын үнэ 4.7 хувиар буурлаа

Хөдөө аж ахуйн биржид голлох түүхий эдийн үнэ буурах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, боловсруулагүй бараан ноолуурын үнэ пүрэв гарагт гурван хувиар буурч, 97 мянган төгрөг болжээ. Харин урт хугацаанд авч үзвэл ханш нь өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өндөр байгаа юм. Түүнчлэн боловсруулагүй цайвар ноолуурын үнэ 4.7 хувиар буурч, 102 мянган төгрөг болсон байна. Энэ нь мөн жилийн дүнгээр 17.9 хувиар өссөн дүн болжээ. Дөрөвдүгээр сар гарснаас хойш Хөдөө аж ахуйн биржид нийт 140.1 тэрбум төгрөгийн түүхий эд арилжаад байна. Өөрөөр хэлбэл арилжааны жилийн өмнөхөөс 12.2 тэрбум төгрөгөөр өсөөд байгаа аж.

2018-2021 онд хэрэгжих "Ноолуур хөтөлбөр" хэрэгжсэнээр ноолуурын экспорт 5.7 дахин өснө гэж тооцоолж байгааг Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн Дэд сайд Ж.Сауле мэдээлж байсан юм. Сүүлийн байдлаар жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд нийт 800 тэрбум төгрөгийн санхүүжилт авахыг хүссэн 1000 гаруй төсөл ирүүлсэн байна. Эдгээр төслүүдийг судалж байна гэж тус сангийн Дэд захирал А.Амаржаргал мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Fitch: Монгол Улсын ДНБ 2018 онд 4.5 хувиар өсөх төлөвтэй

Монгол Улсын эдийн засаг болоод банкны салбарт ойрын хугацаанд тулгарч болох эрсдэлүүд буурч байна гэж "Fitch" агентлаг дүгнэлээ. Учир нь банкнуудын активын чанарт үнэлгээ хийснээр банкны систем дэх хөрөнгийн хүрэлцээтэй байдалтай холбоотой тодорхойгүй буурсан гэж үзэж байна.

Үүнээс гадна нүүрсний экспортод нөлөөлсөн БНХАУ-ын хил дээр саатлыг шийдэхэд ахиц гарч байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлийг бууруулах нөлөөтэй гэж "Fitch" мэдэгдэлдээ онцолжээ. Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг БНХАУ-д айлчилсны дараа буюу дөрөвдүгээр сард боомтын асуудалд ахиц гарч байгааг албаныхан мэдээлсэн юм. 2018 онд эдийн засгийн өсөлт 2017 оныхоос арай доогуур буюу 4.5 хувьтай байна гэж тус агентлаг тооцоолжээ. Хэдий тийм боловч эдийн засгийн орчин нөхцөл сайжрахын хэрээр Монгол Улсын эрх баригчид Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрийн зорилтуудаа хэрэгжүүлэхээс ухрах эрсдэл байгаа гэж тус агентлаг үзэж байна.

Нөгөө талаас эдийн засаг сэргэж, төсвийн сахилга бат сайжирч, гадаад валютын нөөц өсөн нэмэгдэж байгааг мэдэгдэлдээ дурджээ. Мөн Монголбанкны хараат бус байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн реформууд нь хяналт зохицуулалтын бүтцэд байсан дутагдлыг арилгах алхам болж байна гэж "Fitch" үзэж байна. Монголбанкны хувьд санхүүгийн долларжилтыг бууруулах бодлого барьж байгаа юм

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Үүрэн холбооны компаниуд салбарын нийт орлогын 50.26 хувийг бүрдүүлээ

Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчдийн тоо улсын хэмжээнд 2017 онд гурван сая 886 мянга болж өссөн байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны тайлангаас харвал энэ нь дотоодын харилцаа холбооны салбарын хамгийн идэвхтэй үйлчилгээ болж байгаа юм. 2017 оны 12 дугаар сараар эцэслэсэн дүнгээр "Mobicom" корпораци зах зээлийн 38.64 хувийг бүрдүүлж байгаа бол "Unitel" групп зах зээлийн 35.16 хувийг бүрдүүлэх болж, зах зээлд эзлэх хувиа гурав орчим хувиар өсгөсөн байна. Харин "Skytel" групп 15.25 хувийг, "G-Mobile" компани 10.95 хувийг бүрдүүлсэн гэж Харилцаа холбооны зохицуулах хорооноос мэдээллээ. Үүнээс гадна үүрэн холбооны компаниуд салбарын нийт орлогын талыг буюу 50.26 хувийг бүрдүүлж, нийт орлого нь нэг их наяд төгрөгийг давжээ. Орлогын дийлэнх хувийг дата хэрэглээ бүрдүүлсэн байна. Тухайлбал, өнгөрсөн оны байдлаар мобайл дата хэрэглэгчийн тоо хоёр сая 625 мянгад хүрсэн нь жилийн өмнөхөөс долоон хувиар өссөн үзүүлэлт болжээ.

Харин "4G LTE" үйлчилгээг хэрэглэгчийн тоо 2017 онд өмнөх оноос бараг гурав дахин нэмэгдэж, 677 мянгад хүрсэн байна. Хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ өмнөх оноос 51 хувиар өсөж, 26.3 терабайтад хүрчээ. Үүнээс үүрэн холбооны "LTE" хэрэглэгчийн үүсгэсэн дата хэрэглээ 2017 онд 11.5 терабайт болсон аж.

Дата хэрэглээ огцом өсөхөд үүрэн операторууд дата хэрэглээний багц үйлчилгээг идэвхжүүлсэн нь нөлөөлснийг тайлангаас харж болохоор байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн хувьцаа гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байна

"Инвест Монголи Хонг Конг 2018" чуулган 2018 оны 4-р сарын 20-нд Хонг Конг-д зохион байгуулагдсан ба олон улсын банк, санхүүгийн байгууллага, төрийн болон хувийн өмчийн компанийн 120 гаруй төлөөлөгчид оролцсон байна.

Монголын талаас тус чуулганд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайд Д.Сумъяабазар тэргүүнтэй хамт олон оролцсон байна.

Тус чуулганаар Монгол улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчин, Азийн хөрөнгө оруулагчид болон уул уурхайн томоохон төслүүдийн талаар хэлэлцжээ.

БНХАУ-ын томоохон компаниудын төлөөлөгчид болон хөрөнгө оруулагчид ихээхэн анхаарал хандуулав. Чуулганы төгсгөлд Сайд Д.Сумъяабазар алт олборлолт болон эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэлт хөрөнгө оруулж, "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн ордыг олон улсын зах зээлд гаргахыг уриалсан байна.

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Бизнес, хөгжил хариуцсан захирал О.Одбаяр тус компанийн санхүүгийн үзүүлэлт, урт хугацааны стратегийн төлөвлөгөө, хэрэгжүүлж буй төслүүд болон гаргасан хувьцааны талаар танилцуулсан нь хөрөнгө оруулагчдийн анхаарлыг ихээр татжээ.

**Эх сурвалж:** Montsame.mn



### Монголбанк "Цахим мөнгөний журам" баталлаа

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар тодорхойлсон цахим мөнгө, түүний үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, аюулгүй, найдвартай цахим мөнгөний системийг бий болгож хэрэглэгчийг хамгаалах зорилгоор "Цахим мөнгөний журам"-ыг шинээр боловсруулж, баталлаа.

Энэхүү журмыг баталснаар цахим мөнгөний системд хэн, хэрхэн оролцох болон зөвшөөрөл авах үйл явцыг ойлгомжтой болгож, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн эрх, үүргийг тодорхой болгоод зогсохгүй финтек, төлбөрийн системийн цаашдын хөгжлийг дэмжих юм.

**Эх сурвалж:** Mongolbank.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.